ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2024/79/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р бай, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024.02.09 № 13.

танай ________ -ны № ________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Сайнцагаан Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэн 6,310.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, 13.7-д /*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*/, Төсвийн тухай хуулийн 16.5-д /*Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*/, 16.5.5-д /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/ тус тус зөрчсөн байна. Аудитаар илэрсэн нийт залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 10.2 сая төгрөгөөр их байгаа нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө 819.1 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнээс 71.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 747.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан;

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.5 дахин өссөн. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

0212402332

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэн гүйлгээ хийж, хуулиар олгосон албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн, хууль бус гүйлгээг хүлээн зөвшөөрч, албан тушаалын тодорхойлолтод заасан эрх, үүргээ хэтрүүлж баталсан, өөрийн харилцах дансаар мөнгө хүлээн авсан байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд огт хяналт шалгалт хэрэгжүүлээгүй, төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар нь төсөв санхүүд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй асуудал нь нөлөө бүхий эрсдэлтэй асуудал байлаа.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 73 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, Сайнцагаан сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 97.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **336,341,039.50** | **350,059,790.94** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | | **8,725,887.44** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | 8,725,887.44 |
| 31210 | Төгрөг | | 8,725,887.44 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | | 8,725,887.44 |
| **33** | **АВЛАГА** | **7,836,524.34** | **33,988.34** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 15,817.00 | 15,817.00 |
| 33101 | Цалингийн авлага | 15,817.00 | 15,817.00 |
| 33500 | Бусад авлага | 7,820,707.34 | 18,171.34 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 2,000.00 | 2,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 7,818,707.34 | 16,171.34 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **252,014,515.16** | **264,809,915.16** |
| 35100 | Түүхий эд материал | 12,259,500.00 | 12,259,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,259,500.00 | 12,259,500.00 |
| 35400 | Хангамжийн материал | 108,341,015.16 | 121,136,415.16 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,160,100.00 | 5,882,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 101,968,515.16 | 102,824,715.16 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 7,100,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,212,400.00 | 5,329,400.00 |
| 35600 | Мал амьтад | 131,414,000.00 | 131,414,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **76,490,000.00** | **76,490,000.00** |
| 36900 | БЗЭ буй эргэлтийн бус хөрөнгө | 76,490,000.00 | 76,490,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **2,338,262,183.20** | **2,797,003,318.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,338,262,183.20** | **2,797,003,318.98** |
| 39200 | Биет хөрөнгө | 2,145,925,183.20 | 2,601,388,356.52 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,213,509,091.77 | 2,783,891,753.77 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (365,112,064.92) | (585,937,543.44) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 136,877,850.00 | 249,808,533.44 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (19,316,097.38) | (72,707,723.36) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 163,516,770.00 | 264,814,098.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (30,535,207.90) | (90,837,736.44) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 64,608,458.00 | 71,633,718.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (27,914,759.11) | (41,341,528.81) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,336,000.00 | 27,821,860.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө | (3,044,857.26) | (5,757,074.64) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 192,337,000.00 | 195,614,962.46 |
| 39301 | Програм хангамж | 1,960,000.00 | 7,406,625.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | (600,000.00) | (2,768,662.54) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 190,977,000.00 | 190,977,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **2,674,603,222.70** | **3,147,063,109.92** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | **708,856.37** | **672,066.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **708,856.37** | **672,066.00** |
| 41300 | Өглөг | 708,856.37 | 672,066.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 708,856.37 | 441,416.00 |
| 41311 | Цалингийн өглөг | | 441,416.00 |
| 41312 | НДШ-ийн өглөг | 708,856.37 | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 230,650.00 |
| 413201 | Бичиг хэргийн өглөг | | 86,500.00 |
| 413213 | Бусад зардлын өглөг | | 144,150.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **2,673,894,366.33** | **3,146,391,043.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,673,894,366.33** | **3,146,391,043.92** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 642,447,254.10 | 642,447,254.10 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 642,447,254.10 | 642,447,254.10 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,924,010,039.25 | 2,396,506,716.84 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,924,010,039.25 | 1,917,785,637.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 478,721,079.56 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 107,437,072.98 | 107,437,072.98 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | **2,674,603,222.70** | **3,147,063,109.92** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,409,751,913.54** | **2,274,232,448.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **490,451,648.16** | **761,689,075.88** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 490,451,648.16 | 761,689,075.88 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 14,225,887.44 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | | 14,225,887.44 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 286,747,648.16 | 747,463,188.44 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | 203,704,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **919,300,265.38** | **1,512,543,372.38** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 97,875,365.38 | 79,690,472.38 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 35,000,000.00 | 50,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 37,305,700.00 | 20,026,627.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 25,569,665.38 | 9,663,845.38 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 821,424,900.00 | 1,432,852,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 821,424,900.00 | 1,432,852,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **1,081,186,345.90** | **1,794,521,872.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,081,186,345.90** | **1,794,521,872.12** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 998,440,389.82 | 1,590,619,713.84 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 439,866,976.58 | 676,590,855.41 |
| 210101 | Үндсэн цалин | 329,206,457.19 | 466,541,918.44 |
| 210102 | Нэмэгдэл | 83,666,122.69 | 163,519,599.77 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 14,959,000.00 | 27,060,000.00 |
| 210104 | Урамшуулал | 12,035,396.70 | 19,469,337.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,534,215.81 | 83,983,322.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,058,976.55 | 58,384,051.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,493,584.58 | 6,868,464.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,584,136.24 | 5,289,782.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 853,854.47 | 1,320,163.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,543,663.97 | 12,120,859.74 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 60,172,981.67 | 66,479,357.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,598,717.67 | 6,489,013.74 |
| 210302 | Түлш, халаалт | 51,764,880.00 | 57,869,940.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,809,384.00 | 2,120,404.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 106,345,174.70 | 69,410,856.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,406,475.00 | 6,560,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,269,883.70 | 55,042,689.10 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,167,150.00 | 3,759,580.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 60,501,666.00 | 4,048,487.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,467,900.00 | 25,366,550.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,467,900.00 | 25,366,550.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,756,500.00 | 5,590,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,756,500.00 | 5,590,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 94,761,996.57 | 109,260,247.46 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 92,291,664.57 | 108,526,613.86 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,692,600.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 329,732.00 | 263,633.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 360,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 235,534,644.49 | 553,938,524.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 87,805,900.00 | 200,066,600.53 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,069,200.00 | 687,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 146,659,544.49 | 353,184,424.11 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 82,745,956.08 | 203,902,158.28 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 62,514,000.00 | 39,034,150.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,101,300.00 | 8,532,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 39,342,700.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,070,000.00 | 30,501,750.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 20,231,956.08 | 164,868,008.28 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,231,956.08 | 164,868,008.28 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **328,565,567.64** | **479,710,576.14** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **58,309,894.06** | **989,496.58** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 58,309,894.06 | 989,496.58 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 58,309,894.06 | 375,496.58 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - үндсэн хөрөнгө | | 614,000.00 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **270,255,673.58** | **478,721,079.56** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **919,300,265.38** | **1,534,588,059.82** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **22,044,687.44** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | | 22,044,687.44 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 22,044,687.44 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 7,818,800.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | | 14,225,887.44 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **919,300,265.38** | **1,512,543,372.38** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 97,875,365.38 | 79,690,472.38 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив | 35,000,000.00 | 50,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 37,305,700.00 | 20,026,627.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 25,569,665.38 | 9,663,845.38 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 821,424,900.00 | 1,432,852,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 821,424,900.00 | 1,432,852,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **902,825,265.38** | **1,454,185,902.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **902,825,265.38** | **1,454,185,902.38** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 820,079,309.30 | 1,250,283,744.10 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 447,701,499.92 | 676,874,559.78 |
| 210101 | Үндсэн цалин | 337,040,980.53 | 466,825,622.81 |
| 210102 | Нэмэгдэл | 83,666,122.69 | 163,519,599.77 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 14,959,000.00 | 27,060,000.00 |
| 210104 | Урамшуулал | 12,035,396.70 | 19,469,337.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,825,360.44 | 83,983,322.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,350,121.18 | 58,384,051.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,493,584.58 | 6,868,464.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,584,136.24 | 5,289,782.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 853,854.47 | 1,320,163.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,543,663.97 | 12,120,859.74 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 60,172,981.67 | 66,479,357.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,598,717.67 | 6,489,013.74 |
| 210302 | Түлш, халаалт | 51,764,880.00 | 57,869,940.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,809,384.00 | 2,120,404.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 45,115,153.70 | 72,104,546.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,468,450.00 | 9,200,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,838,853.70 | 55,042,689.10 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,167,150.00 | 3,759,580.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,640,700.00 | 4,101,977.00 |
| 2105 | Нормативт зардал | 240,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 240,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,720,400.00 | 33,724,450.00 |
| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
| 210604 | Урсгал засвар | 1,720,400.00 | 33,724,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,756,500.00 | 5,590,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,756,500.00 | 5,590,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 94,761,996.57 | 109,260,247.46 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 92,291,664.57 | 108,526,613.86 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,692,600.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 329,732.00 | 263,633.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 360,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,785,417.00 | 202,267,260.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,906,617.00 | 201,579,760.53 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,878,800.00 | 687,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 82,745,956.08 | 203,902,158.28 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 62,514,000.00 | 39,034,150.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,101,300.00 | 8,532,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 39,342,700.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,070,000.00 | 30,501,750.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 20,231,956.08 | 164,868,008.28 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,231,956.08 | 164,868,008.28 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **16,475,000.00** | **80,402,157.44** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **16,475,000.00** | **71,676,270.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **16,475,000.00** | **71,676,270.00** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 16,475,000.00 | 71,676,270.00 |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 16,475,000.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 16,475,000.00 | 71,676,270.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **(16,475,000.00)** | **(71,676,270.00)** |
| **9** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | |
| **10** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)** | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | | **8,725,887.44** |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **8,725,887.44** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **642,447,254.10** | **107,437,072.98** | **1,653,754,365.67** | **2,403,638,692.75** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 642,447,254.10 | 107,437,072.98 | 1,653,754,365.67 | 2,403,638,692.75 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | | |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 8 | Зарласан ноогдол ашиг | | | | |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 270,255,673.58 | 270,255,673.58 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **642,447,254.10** | **107,437,072.98** | **1,924,010,039.25** | **2,673,894,366.33** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (6,224,401.97) | (6,224,401.97) |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 642,447,254.10 | 107,437,072.98 | 1,917,785,637.28 | 2,667,669,964.36 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | | |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 18 | Зарласан ноогдол ашиг | | | | |
| **19** | **Тайлант үеийн үр дүн** | | | **478,721,079.56** | **478,721,079.56** |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **642,447,254.10** | **107,437,072.98** | **2,396,506,716.84** | **3,146,391,043.92** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | | |
| **11100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | | |
| **11200** | **Кассын оны эхний үлдэгдэл** | | | |
| **12** | **Татварын бус орлого** | **1,518,851,900.00** | **1,282,077,878.10** | **236,774,021.90** |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | | 7,818,800.00 | (7,818,800.00) |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,518,851,900.00 | 1,274,259,078.10 | 244,592,821.90 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,518,851,900.00** | **1,282,077,878.10** | **236,774,021.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,518,851,900.00** | **1,282,077,878.10** | **236,774,021.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,466,961,900.00** | **1,244,493,728.10** | **222,468,171.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **760,658,800.00** | **676,874,559.78** | **83,784,240.22** |
| 210101 | Үндсэн цалин | 518,295,200.00 | 466,825,622.81 | 51,469,577.19 |
| 210102 | Нэмэгдэл | 173,863,100.00 | 163,519,599.77 | 10,343,500.23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 37,728,500.00 | 27,060,000.00 | 10,668,500.00 |
| 210104 | Урамшуулал | 30,772,000.00 | 19,469,337.20 | 11,302,662.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **90,003,900.00** | **83,983,322.49** | **6,020,577.51** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,009,200.00 | 58,384,051.90 | 1,625,148.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,498,700.00 | 6,868,464.62 | 630,235.38 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,998,900.00 | 5,289,782.25 | 709,117.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,499,900.00 | 1,320,163.98 | 179,736.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,997,200.00 | 12,120,859.74 | 2,876,340.26 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **77,278,400.00** | **66,479,357.74** | **10,799,042.26** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,996,900.00 | 6,489,013.74 | 3,507,886.26 |
| 210302 | Түлш, халаалт | 62,281,500.00 | 57,869,940.00 | 4,411,560.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,000,000.00 | 2,120,404.00 | 2,879,596.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **94,571,600.00** | **68,818,336.10** | **25,753,263.90** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,281,400.00 | 7,811,800.00 | 469,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 68,540,500.00 | 53,144,979.10 | 15,395,520.90 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,031,500.00 | 3,759,580.00 | 271,920.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,060,000.00 | | 1,060,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,658,200.00 | 4,101,977.00 | 8,556,223.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **900,000.00** | | **900,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 900,000.00 | | 900,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **128,700,000.00** | **99,494,920.00** | **29,205,080.00** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 76,700,000.00 | 65,770,470.00 | 10,929,530.00 |
| 210604 | Урсгал засвар | 52,000,000.00 | 33,724,450.00 | 18,275,550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **14,937,400.00** | **5,590,000.00** | **9,347,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,937,400.00 | 5,590,000.00 | 9,347,400.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж** | **75,196,100.00** | **57,226,641.46** | **17,969,458.54** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 66,455,500.00 | 56,493,007.86 | 9,962,492.14 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,698,500.00 | | 5,698,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,378,800.00 | 263,633.60 | 1,115,166.40 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 651,900.00 | 110,000.00 | 541,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 629,000.00 | 360,000.00 | 269,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 382,400.00 | | 382,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **224,715,700.00** | **186,026,590.53** | **38,689,109.47** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 223,275,700.00 | 185,339,090.53 | 37,936,609.47 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,440,000.00 | 687,500.00 | 752,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,890,000.00** | **37,584,150.00** | **14,305,850.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 9,690,000.00 | 8,532,400.00 | 1,157,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 42,200,000.00 | 29,051,750.00 | 13,148,250.00 |
| **12000** | **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | |
| **12100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | | |
| **12200** | **Тусламжийн орлого** | **1,518,851,900.00** | **1,274,259,078.10** | **244,592,821.90** |
| **12200** | **Кассын дансны эцсийн үлдэгдэл** | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **79,690,472.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **79,690,472.38** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **71,966,286.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,286,210.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,388,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,897,710.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **53,683,606.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 53,023,606.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 660,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,996,470.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,996,470.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,724,186.38** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,450,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,450,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **6,274,186.38** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,274,186.38 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **79,690,472.38** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **79,690,472.38** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **79,690,472.38** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 50,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 20,026,627.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,663,845.38 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| **11000** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **12000** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 349,239.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 310,480.6 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 14,128.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 24,630.0 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, 2 сахилгын хариуцлага тооцох албан шаардлага тус тус хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт 310,480.6 мянган төгрөгийн 7 алдаа[1] илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 1,361.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

2. Нэр данс зөрүүтэй 526.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор тайлагнасан.
3. Албан хаагчдын 47,605.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалинг шууд зардлаар тайлагнасан.
4. Хандиваар ирсэн 50,000.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд зөрүүтэй тайлагнасан.
5. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 158,593.8 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг дансыг цэвэрлэх бичилт хийгээгүй
6. Орон нутгийн төсвөөс олгосон 38,164.4 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу тайлагнасан.
7. Ахмадын сангаас шилжиж ирсэн 14,225.9 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 38,758.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 14,128.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 24,630.0 мянган төгрөгийн зөрчил арилгах хугацаатай албан шаардлага, 2 сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага хүргүүллээ.

## 2.1 Төлбөрийн акт

- ✓ Шүүхийн шийдвэрээр буцаж ажилдаа орсон албан хаагчийн ажилгүй байсан хугацааны 7,818.7 мянган төгрөгийн цалин хөлсийг цалингийн зардлаас гаргаж авлагаар бүртгэсэн ч холбогдох буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д /*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*/, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д /*Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ*/, Иргэний хуулийн 498.1-т /*Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ*/, 498.5-д /*Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй*/ заасныг тус тус зөрчсөн.
- ✓ Анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэн 6,310.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, 13.7-д /*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*/, Төсвийн тухай хуулийн 16.5-д /*Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*/, 16.5.5-д /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/ заасныг тус тус зөрчсөн.

## 2.2 Албан шаардлага

- ✓ Төсвийн хөрөнгийг тушаал шийдвэргүй, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамааралгүй зардалд зориулалт бусаар 2,780.0 мянган төгрөгийг зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6-д /*үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх*/, 15.1-т /*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*/, 15.1.5-д /*төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах*/ заасныг;
- ✓ Өлзийт-Мандал өрхийн эмнэлгийн барилгын өргөтгөлийн 19,950.0 мянган төгрөгийн зураг төсвийг хөрөнгийн дансанд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т /*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/ заасныг;

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- ✓ Нэг удаагийн шагнал урамшууллын 1,900.0 мянган төгрөгийг урсгал засварын зардлаас зарцуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, 16.5.5-д /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т /*Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна*/ заасныг;
- ✓ Анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлсэн хууль бус гүйлгээг хүлээн зөвшөөрч, албан тушаалын тодорхойлолтод заасан эрх, үүргээ хэтрүүлж баталсан, өөрийн харилцах дансаар мөнгө хүлээн авсан. Энэ нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10-т /*Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана*/ заасныг;
- ✓ Анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэн гүйлгээ хийж, хуулиар олгосон албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, 13.7-д /*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/ зөрчсөн зэрэг зөрчлүүдэд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг илүү тайлагнасан. | 1 | 1,361.5 | | | 1 | 1,361.5 | 1 | 1,361.5 | | |
| Нэр данс зөрүүтэй орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор тайлагнасан. | 1 | 526.0 | | | 1 | 526.0 | 1 | 526.0 | | |
| Албан хаагчдын урьдчилгаа цалинг шууд зардлаар тайлагнасан. | 1 | 47,605.0 | | | 1 | 47,605.0 | 1 | 47,605.0 | | |
| Хандиваар ирсэн мөнгөн хөрөнгийг үр дүнгийн тайланд зөрүүтэй тайлагнасан. | 1 | 50,000.0 | | | 1 | 50,000.0 | 1 | 50,000.0 | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг дансыг цэвэрлэх бичилт хийгээгүй | 1 | 158,593.8 | | | 1 | 158,593.8 | 1 | 158,593.8 | | |
| Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг дутуу тайлагнасан | 1 | 38,168.4 | | | 1 | 38,168.4 | 1 | 38,168.4 | | |
| Ахмадын сангаас шилжиж ирсэн мөнгөн хөрөнгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн. | 1 | 14,225.9 | | | 1 | 14,225.9 | 1 | 14,225.9 | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **7** | **310,480.7** | - | - | **7** | **310,480.7** | **7** | **310,480.7** | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төсвийн хөрөнгийг тушаал шийдвэргүй, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамааралгүй зардалд зориулалт бусаар зарцуулсан. | 1 | 2,780.0 | | | 1 | 2,780.0 | | | | |
| Шүүхийн шийдвэрээр буцаж ажилдаа орсон албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг цалингийн зардлаас гаргаж авлагаар бүртгэсэн ч холбогдох буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй. | 1 | 7,818.7 | 1 | 7,818.7 | | | | | | |
| Анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэн гүйлгээ хийж  зарцуулсан. | 1 | 6,310.0 | 1 | 6,310.0 | | | | | | |
| Нэг удаагийн шагнал урамшууллыг урсгал засварын зардлаас зарцуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. | 1 | 1,900.0 | | | 1 | 1,900.0 | | | | |
| Өлзийт-Мандал өрхийн эмнэлгийн барилгын өргөтгөлийн зураг төсвийг хөрөнгийн дансанд бүртгэсэн. | 1 | 19,950.0 | | | 1 | 19,950.0 | | | | |
| Дүн | 7 | 38,758.7 | 2 | 14,128.7 | 3 | 24,630.0 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**
/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлсэн хууль бус гүйлгээг хүлээн зөвшөөрч, албан тушаалын тодорхойлолтод заасан эрх, үүргээ хэтрүүлж баталсан, өөрийн харилцах дансаар мөнгө авсан. | 1 | | | | | | 1 | |
| Анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэн гүйлгээ хийж, хуулиар олгосон албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн байна | 1 | | | | | | 1 | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 2 | | | | | | 2 | |